



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/35/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Цог-Эрдэнэ Утас: 99210906 Цахим хаяг: Tsogerdene.g@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. Аудитын дүгнэлт

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	15
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг 14.4 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг алдаа илэрсэнд аудитын явцад залруулга аудитын явцад залрууллаа. ....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.2 Албан шаардлага .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4.3 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	17
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар

ТБОНӨТХ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.25 № 124  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ТӨВИЙН ДАРГА Б.ЭРДЭНЭЧИМЭГ  
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхгүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,599,453.73	44,384,906.28
2	БАРАА МАТЕРИАЛ	34,599,453.73	44,384,906.28
3	Түүхий эд материал	16,467,301.88	25,526,567.28
4	Эм боох материал	16,467,301.88	25,526,567.28
5	Хангамжийн материал	18,132,151.85	18,858,339
6	Бичиг хэргийн материал	2,714,202.85	1,487,985
7	Аж ахуйн материал	13,806,249	14,953,654
8	Түлш, шатах тослох материал	944,000	1,846,000
9	Барилгын засварын материал	667,700	570,700
10	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	195,489,900.71	189,481,012.62
11	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	195,489,900.71	189,481,012.62
12	Биет хөрөнгө	70,209,900.71	64,201,012.62
13	Барилга, байгууламж, орон сууц	256,649,280.9	256,649,280.9
14	Хуримтлагдсан элэгдэл	-254,886,960	-254,924,490
15	Авто-тээврийн хэрэгсэл	97,819,554	97,819,554
16	Хуримтлагдсан элэгдэл	-47,359,343.09	-51,732,379.25
17	Машин тоног төхөөрөмж(компьютер)	90,713,347.13	95,744,447.13
18	Хуримтлагдсан элэгдэл	-77,194,466.26	-82,992,935.75
19	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,862,305	13,962,305
20	Хуримтлагдсан элэгдэл	-12,905,721.72	-13,122,388.44
21	Бусад үндсэн хөрөнгө	13,488,309.5	13,488,309.5
22	Хуримтлагдсан элэгдэл	-9,976,404.75	-10,690,690.47
23	Биет бус хөрөнгө	125,280,000	125,280,000
24	Бусад биет бус хөрөнгө	125,280,000	125,280,000
25	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	230,089,354.44	233,865,918.9
26	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	230,089,354.44	233,865,918.9
27	Засгийн газрын хувь оролцоо	230,089,354.44	233,865,918.9
28	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	240,575,168	240,575,168
29	Хуримтлагдсан үр дүн	-12,450,943.81	-8,674,379.35
30	Өмнөх үеийн үр дүн	-38,314,270.49	-12,450,943.81
31	Тайлант үеийн үр дүн	25,863,326.68	3,776,564.46
32	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,965,130.25	1,965,130.25
33	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	230,089,354.44	233,865,918.9

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	430,231,307.6	454,376,518.4
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,144,589.6	18,772,718.4
3	Нийтлэг татварын бус орлого	46,144,589.6	18,772,718.4
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37,900,000	3,931,100
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	8,244,589.6	14,841,618.4
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,086,718	435,603,800
7	Улсын төвлөрсөн төсвөөс	374,679,800	386,484,800
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374,679,800	386,484,800
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,406,918	49,119,000
10	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,845,000
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,406,918	41,274,000
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	404,367,980.92	450,599,953.94
13	УРСГАЛ ЗАРДАЛ	404,367,980.92	450,599,953.94
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,830,014.92	415,270,936.6
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,077,648	292,556,830.89
16	Үндсэн цалин	168,586,700	180,786,983.8
17	Нэмэгдэл	77,959,418	77,484,013
18	Унаа хоолны хөнгөлөлт	15,246,000	12,891,349
19	Урамшуулал	25,285,530	21,394,485.09
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,345,090	39,509,760.39
21	Тэтгэврийн даатгал	25,536,378	25,993,556.92
22	Тэтгэмжийн даатгал	2,788,700	2,839,500
23	ҮОМШӨ-ний даатгал	4,884,812	5,042,697.04
24	Ажилгүйдлийн даатгал	775,700	512,100.63
25	Эрүүл мэндийн даатгал	5,359,500	5,121,905.8
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,703,900	8,180,461.38
27	Гэрэл, цахилгаан	2,743,900	3,150,161.38
28	Түлш, халаалт	3,900,000	5,030,300
29	Цэвэр, бохир ус	60,000	
30	Хангамж, бараа материалын зардал	20,596,385	21,490,662.85
31	Бичиг хэрэг	2,362,645	4,365,867.85
32	Тээвэр, шатахуун	15,959,700	15,759,600
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	484,700	563,700
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		207,720
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,789,340	593,775
36	Нормативт зардал	15,085,817.6	29,505,353
37	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,085,817.6	29,505,353
38	Эд хогшил, урсгал засварын зардал	3,138,500	2,828,100
39	Урсгал засвар	3,138,500	2,828,100
40	Томиллолт, зочны зардал	5,639,000	6,383,200
41	Дотоод албан томиллолт	5,639,000	6,383,200
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,637,474	3,676,580
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000	
44	Даатгалын үйлчилгээ	270,000	1,046,800
45	Тээврийн хэрэгслийн татвар	249,942	280,784
46	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000	93,000
47	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,281,532	1,799,996
48	Газрын төлбөр	336,000	336,000
49	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	140,000	120,000
50	Бараа үйлчилгээний бусад зардал	22,606,200.32	11,139,988.09

51	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,606,200.32	11,139,988.09
52	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,537,966	35,329,017.34
53	Бусад урсгал шилжүүлэг	440,000	30,440,000
54	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		30,000,000
55	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000	440,000
56	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,097,966	4,889,017.34
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,097,966	4,889,017.34
58	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	25,863,326.68	3,776,564.46
59	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	25,863,326.68	3,776,564.46

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-38,314,270.49	204,226,027.76
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-38,314,270.49	204,226,027.76
3	Тайлант үеийн үр дүн			25,863,326.68	25,863,326.68
4	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-12,450,943.81	230,089,354.44
5	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-12,450,943.81	230,089,354.44
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-12,450,943.81	230,089,354.44
7	Тайлант үеийн үр дүн			3,776,564.46	3,776,564.46
8	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	240,575,168	1,965,130.25	-8,674,379.35	233,865,918.9

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	өмнөх он	тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	384,086,718	435,603,800
2	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	384,086,718	435,603,800
3	Улсын төвлөрсөн төсвөөс	374,679,800	386,484,800
4	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374,679,800	386,484,800
5	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,406,918	49,119,000
6	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,845,000
7	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,406,918	41,274,000
8	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	383,006,818	434,403,800
9	УРСГАЛ ЗАРДАЛ	383,006,818	434,403,800
10	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	381,468,852	399,074,782.66
11	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,077,648	292,556,830.89
12	Үндсэн цалин	168,586,700	180,786,983.8
13	Нэмэгдэл	77,959,418	77,484,013
14	Унаа хоолны хөнгөлөлт	15,246,000	12,891,349
15	Урамшуулал	25,285,530	21,394,485.09
16	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,345,090	39,509,760.39
17	Тэтгэврийн даатгал	25,536,378	25,993,556.92
18	Тэтгэмжийн даатгал	2,788,700	2,839,500
19	ҮОМШӨ-ний даатгал	4,884,812	5,042,697.04
20	Ажилгүйдлийн даатгал	775,700	512,100.63
21	Эрүүл мэндийн даатгал	5,359,500	5,121,905.8
22	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,997,900	9,082,461.38
23	Гэрэл, цахилгаан	2,743,900	3,150,161.38
24	Түлш, халаалт	4,194,000	5,932,300
25	Цэвэр, бохир ус	60,000	
26	Хангамж, бараа материалын зардал	22,262,300	20,792,950
27	Бичиг хэрэг	3,120,000	3,118,350
28	Тээвэр, шатахуун	15,759,700	15,759,600
29	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000	585,000
30	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000	830,000
31	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,797,600	500,000
32	Нормативт зардал	13,173,972	23,723,000
33	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,119,972	19,635,000
34	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,054,000	4,088,000
35	Эд хогшил, урсгал засварын зардал	3,817,000	3,350,000
36	Багаж, техник, хэрэгсэл	117,000	
37	Урсгал засвар	3,700,000	3,350,000
38	Томилолт, зочны зардал	5,639,000	6,383,200
39	Дотоод албан томилолт	5,639,000	6,383,200
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,155,942	3,676,580
41	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000	
42	Даатгалын үйлчилгээ	270,000	1,046,800
43	Тээврийн хэрэгслийн татвар	249,942	280,784
44	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000	93,000
45	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000	1,799,996
46	Газрын төлбөр	336,000	336,000
47	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	140,000	120,000
48	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,537,966	35,329,017.34
49	Бусад урсгал шилжүүлэг	440,000	30,440,000
50	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		30,000,000

51	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000	440,000
52	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,097,966	4,889,017.34
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,097,966	4,889,017.34
54	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,079,900	1,200,000
55	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,079,900	1,200,000
56	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,079,900	1,200,000
57	Дотоод эх үүсвэрээр	1,079,900	1,200,000
58	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,079,900	1,200,000
59	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,079,900	-1,200,000
60	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,484,800	382,395,782.66	4,089,017.34	98.94
2	УРСГАЛ ЗАРДАЛ	386,484,800	382,395,782.66	4,089,017.34	98.94
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,044,800	381,955,782.66	4,089,017.34	98.94
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	283,947,700	282,082,830.89	1,864,869.11	99.34
5	Үндсэн цалин	184,082,600	180,786,983.80	3,295,616.20	98.21
6	Нэмэгдэл	56,280,700	67,010,013	10,729,313.00	119.06
7	Унаа хоолны хөнгөлөлт	15,972,000	12,891,349	3,080,651.00	80.71
8	Урамшуулал	27,612,400	21,394,485.09	6,217,914.91	77.48
9	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,172,500	39,509,760.39	1,662,739.61	95.96
10	Тэтгэврийн даатгал	26,975,000	25,993,556.92	981,443.08	96.36
11	Тэтгэмжийн даатгал	2,839,500	2,839,500	0.00	100.00
12	ҮОМШӨ-ний даатгал	5,111,100	5,042,697.04	68,402.96	98.66
13	Ажилгүйдлийн даатгал	567,900	512,100.63	55,799.37	90.17
14	Эрүүл мэндийн даатгал	5,679,000	5,121,905.80	557,094.20	90.19
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,542,400	9,082,461.38	459,938.62	95.18
16	Гэрэл, цахилгаан	3,609,800	3,150,161.38	459,638.62	87.27
17	Түлш, халаалт	5,794,000	5,932,300	-138,300.00	102.39
18	Цэвэр, бохир ус	138,600		138,600.00	-
19	Хангамж, бараа материалын зардал	20,794,600	20,792,950	1,650.00	99.99
20	Бичиг хэрэг	3,120,000	3,118,350	1,650.00	99.95
21	Тээвэр, шатахуун	15,759,600	15,759,600	0.00	100.00
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000	585,000	0.00	100.00
23	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	830,000	830,000	0.00	100.00
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000	500,000	0.00	100.00
25	Нормативт зардал	15,878,000	15,878,000	0.00	100.00
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,790,000	11,790,000	0.00	100.00
27	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,088,000	4,088,000	0.00	100.00
28	Эд хогшил, урсгал засварын зардал	4,550,000	4,550,000	0.00	100.00
29	Багаж, техник, хэрэгсэл	1,200,000	1,200,000	0.00	100.00
30	Урсгал засвар	3,350,000	3,350,000	0.00	100.00
31	Томилолт, зочны зардал	6,439,800	6,383,200	56,600.00	99.12
32	Дотоод албан томилолт	6,439,800	6,383,200	56,600.00	99.12

**Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

33	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,719,800	3,676,580	43,220.00	98.84
34	Даатгалын үйлчилгээ	1,046,800	1,046,800	0.00	100.00
35	Тээврийн хэрэгслийн татвар	315,000	280,784	34,216.00	89.14
36	Тээврийн хэрэгслийн оношлогоо	93,000	93,000	0.00	100.00
37	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800,000	1,799,996	4.00	100.00
38	Газрын төлбөр	336,000	336,000	0.00	100.00
39	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	129,000	120,000	9,000.00	93.02
40	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	440,000	440,000	0.00	100.00
41	Бусад урсгал шилжүүлэг	440,000	440,000	0.00	100.00
42	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	440,000	440,000	0.00	100.00
43	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,484,800	386,484,800	0.00	100.00
44	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	386,484,800	386,484,800	0.00	100.00
45	Улсын төсвөөс санхүүжих	386,484,800	386,484,800	0.00	100.00
46	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
47	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00
48	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	0.00	100.00
49	Удирдах ажилтан	1	1	0.00	100.00
50	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.00
51	Үйлчлэх ажилтан	4	4	0.00	100.00
52	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22	22	0.00	100.00
53	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	15	15	0.00	100.00
54	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	7	0.00	100.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөг /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	48,319,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	48,319,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,319,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,474,000.00
210102	Нэмэгдэл	10,474,000.00
2105	Нормативт зардал	7,845,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,845,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	30,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49119000.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,119,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,845,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,274,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зоонозын өвчин судлалын төв нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн албан шаардлагыг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Зоонозын өвчин судлалын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25 -ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зоонозын өвчин судлалын төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “хүн амын эрүүл мэндийг төрийн онцгой анхаарал, ивээлд авах”, 4.1.2-д “хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх”, 4.2.1-д “хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтэт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх”, 4.2.2-д “нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож, улмаар эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхэд эрүүл мэндийн байгууллагын бие даасан, нээлттэй, өмчийн олон хэлбэрт тулгуурласан байдлыг хангах” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд “Зоонозын халдварт өвчиний эрсдэлгүй орчнийг бүрдүүлж эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээний тусламж үйлчилгээг чанартай хүргэж, хүний өвчлөл эндэглэгийг бууруулна” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/496 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн А/585 дугаар тушаал “Нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох тухай”
- Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/605 дугаар тушаал “Журам, аргачлал батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын нэгжгүй тул үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт, аудитын албанаас төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зоонозын өвчин судлалын төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 386.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 3.8 сая төгрөгөөр буюу 1.6 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая.төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	34.60	44.38	9.79	28.28
Үндсэн хөрөнгө	195.49	189.48	(6.01)	(3.07)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>230.09</b>	<b>233.87</b>	<b>3.78</b>	<b>1.64</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	230.09	233.87	3.78	1.64
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>230.1</b>	<b>233.9</b>	<b>3.8</b>	<b>1.6</b>

- Бараа материалын үлдэгдэл 28.3 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 34.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 53.2 сая төгрөг, хандиваар хүлээн авсан 14.8 сая төгрөг нийт 68.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 58.3 сая төгрөгийн зарцуулалт гарч, 44.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 3.7 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 195.5 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 1.2 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 3.9 сая төгрөг нийт 5.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 11.1 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 189.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 3.8 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/ төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	374.68	386.48	11.81
Нэмэлт санхүүжилтийн орлого	9.41	49.12	39.71
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	37.90	3.93	(33.97)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	14.84	14.84
<b>Үйл ажиллагааны орлого</b>	<b>421.99</b>	<b>454.38</b>	<b>32.39</b>
Цалин, шимтгэлийн зардал	326.42	332.07	5.64
Бусад бараа үйлчилгээний зардал	76.41	83.20	6.79
Урсгал шилжүүлэг	1.54	35.33	33.79
<b>Үйл ажиллагааны зардал</b>	<b>404.37</b>	<b>450.60</b>	<b>46.23</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>17.61</b>	<b>3.78</b>	<b>(13.84)</b>

Зоонозын өвчин судлалын төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 11.8 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн нь ковид 19 холбоотойгоор эм, эмнэлгийн хэрэгсэл, томилолтын зардал болон ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 469.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 82.9 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 386.5 сая төгрөгөөр хянаж баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 386.5 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч 4.0 сая төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгож улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМГ-аас 41.3 сая төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас 7.8 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Аймгийн ЭМГ-аас Эрүүл Мэндийн Сайдын 2021 оны А/496, А/585 тушаалын дагуу нэгдсэн эмнэлгийн 22 албан хаагчдад нэг удаагийн тэтгэмж урамшуулалд зориулж 30.0 сая төгрөгийг, цалин урамшуулалд 10.4 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Мөн аймгийн Засаг даргын нөөц сангаас шилжүүлсэн 7.8 сая төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтээс 0.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

COVID-19-ын урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг 897 объектын 576323.4 метр/кв талбайд Эцсийн халдваргүйжүүлэлтийг 2177 объектын 387964.4 метр.квадрат талбайд хийж гүйцэтгэсэн байна. Мөн химийн аргаар 1351, даралтат уураар 4987, хуурай халуунаар 5522 нэгж материал ариутгасан байна. Лабораторийн шинжилгээний үед байнгын халдваргүйжүүлэлт 4106 удаа, эцсийн халдваргүйжүүлэлт 45 удаа тус тус хийж гүйцэтгэсэн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 98 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 386.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 98.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Ковид 19 цар тахалтай холбоотойгоор аймгийн ЭМГ-аас 14.8 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн материал хандиваар орж ирсэн бүртгэл тайланд тусгаж, 13.3 сая төгрөгийг зарцуулж, 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: тус байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 4 тээврийн хэрэгсэлд 15.7 сая төгрөгийн шатахуун, 2.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл зарцуулсан, орон тооны 3 жолоочтой, жолоочийн цалинд 38.3 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Зооноз өвчин судлалын төв нь 2021 онд нийт 386.4 сая төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 386.4 сая төгрөгийн 84 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулсан байна. 35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, 2022 оны шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд тогтмол, бүрэн мэдээлэх албан шаардлага хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 15.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 заалт бүхий зөвлөмж өглөө.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 15.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр заалтын дагуу ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллах

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал													
1	ЗӨСТ	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 33 нэр төрлийн 15.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1	15.1								1	15.1
Дүн			1	15.1								1	15.1
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал													
1	ЗӨСТ	35 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1									1	
Дүн			1									1	
Нийт дүн			2	15.1								1	15.1